

СҮХБААТАР АЙМГИЙН ХАЛЗАН СУМЫН ЗАСАГ ДАРГЫН
ТАМГЫН ГАЗРЫН 2021 ОНЫ 09 ДҮГЭЭР САРЫН МЭДЭЭ

НЭГ. ТӨРИЙН УДИРДЛАГЫН ХҮРЭЭНД

Сүхбаатар аймгийн сумдын Иргэдийн төлөөлөгчдийн хурлын нарийн бичгийн дарга нарыг чадавхжуулах сургалт уулзалт 2021 оны 09 сарын 24-ны өдөр зохион байгуулагдаж сургалтанд нарийн бичиг оролцоод ирсэн.

Мөн Иргэдийн Төлөөлөгчдийн хурлын ажлын албанаас төлөөлөгчдийн идэвхийг сайжруулах, мэдээ мэдээлэлээр хангах зорилгоор 2021 онд хурлаас гарсан тэргүүлэгчдийн тогтоол, ИТХ-аас гарсан тогтоол шийдвэр, төлөвлөгөө журам, ажлын албаны мэдээлэл, төлөөлөгч нарт арга зүйн зөвлөгөө өгөх, хоорондын уялдаа холбоог сайжруулахаар хурлын ажлын албаны цахим группт байршуулан хурлын төлөөлөгч нарт мэдээ мэдээлэлийг цаг алдалгүй хүргэн ажиллаж байна.

2021 онд сумын Иргэдийн Төлөөлөгчдийн Хурал 3 удаа, тэргүүлэгчид 4 удаа хуралдсан байна.

б/ Тамгын газар төрийн удирдлагын ажлын чиглэлээр: 9 дүгээр сарын 07 ны өдөр сумын онцгой комисс хуралдаж дараах шийдвэрүүдийг гарган ажиллав. Үүнд: Гамшгийн үед ажиллах ажлын хэсгийг шинэчлэн томилгоожуулсан. Соёлын төвийг Тусгаарлан эмчлэх байрны зориулалтаар ашиглах мөн соёлын төвийн гадаа гал тогоо, эмч нар байрлах 2 гэр барьж ажиллалаа.

Ашиглаж байсан усны машиныг онгон сумруу балансаас балансруу шилүүлсэн. Гамшгаас хамгаалах зардлыг ИТХ аас 10 сая төгрөгөөр тодотгол хийж 20 ширхэг эвхдэг ор авч ажиллав.

Хөдөлмөрийн зах зээлийн судалгааг нийт төрийн албан байгууллагуудаас авч нэгтгэн хүргүүлэн ажиллав. Мөн сул орон тооны зарыг аймгийн ТЗҮХ-т хүргүүллээ

ХОЁР. САНХҮҮ, ЭДИЙН ЗАСГИЙН БОДЛОГЫН ХҮРЭЭНД:

9 дүгээр сард татварын орлого 170983,5 мянган төгрөг, аймгаас авах санхүүгийн дэмжлэгээр 52989,7 мянган төгрөг орсон байна. 6 ш Шонхор шувууны орлого 163814,4 мянган төгрөг дансанд төвлөрсөн байна. Зарлагын хувьд:

➤ ЗДТГ-51548,7 мян/төг

- ИТХ-5774,0 мян/төг
- Соёл-13043,3 мян/төгрөгийн санхүүгийн дэмжлэг олголоо.

Тусгай зориулалтын шилжүүлгээр санхүүждэг төсөвт байгууллагын хувьд:

- ЕБС-43166,5 мян/төг
- СӨБ-19724,8 мян/төг
- ЭМТ-31767,1 мян/төгрөгийн санхүүжилт авсан байна.

Сум хөгжүүлэх сангийн зээлийн эргэн төлөлтөөс энэ сард 944,0 мянган төгрөг дансанд төвлөрч, дансны үлдэгдэл 121043,1 мянган төгрөг байна.

ОНХС-ийн дансны үлдэгдэл 32021,0 мянган төгрөг байна. Энэ сард Гамшгаас хамгаалах зардалд 10000,0 сая төгрөгийн санхүүгийн дэмжлэг олгож, зарцуулалт 5168,5 мянган төгрөг гарч, дансны үлдэгдэл 4831,5 мянган төгрөг байна.

ГУРАВ. ХУУЛЬ ЭРХ ЗҮЙН АЖЛЫН ХҮРЭЭНД:

Хөдөлмөрийн тухай хууль болон Монгол улсын Засаг захиргаа нутаг дэвсгэрийн нэгж түүний удирдлагын тухай хуулиар сонсгол мэдээллийн цагаар мэдээлэл өгч ажиллалаа.

ДӨРӨВ. БОЛОВСРОЛ, СОЁЛ, ЭРҮҮЛ МЭНД, НИЙГМИЙН ХАМГААЛЛЫН БОДЛОГЫН ХҮРЭЭНД:

Хүүхдийн цэцэрлэг: Туршилтын талбайд тарьсан хүнсний ногоогоо хураан авч хүнсэндээ хэрэглэж байна. Мөн байгалийн булан шинээр тохижуулан ажиллалаа.

6.Хүүхэд хүлээн авах бэлтгэл ажлуудыг хийж, Цэцэрлэгийн хашааны гадна талд хулдаасан санамжуудыг байрлуулан ажиллав.

Соёлын чиглэлээр: Халзан сум соёлын төвийн үйл ажиллагаа нь цар тахалтай холбоотойгоор олон нийтийн арга хэмжээг зохион байгуулахгүй байна. Корона вирусын тархац эрчимтэй нэмэгдэж эрүүл мэндийн төв ачаалалаа дийлэхгүй болж Соёлын төвийг тусгаарлан ажиглах эмчлэх байр болгон ажиллаж байна.

Монгол Улсын Засаг захиргаа нутаг дэвсгэрийн нэгж түүний удирдлагын тухай хуулийн 33 дугаар зүйлийн 33.5, Гамшигаас хамгаалах тухай хуулийн 34 дүгээр зүйлийн 34.1. 34.1.2, 34.2, 34.2.6 заалтуудыг үндэслэн байгууллагынхаа ажилчдын дархлааг дэмжиэ ажиллалаа.

Байгууллагын гэрлэн хаяг гадна орчны гэрэлтүүлэгт зориулан нэмэлт санхүүжилтын зардлаас 1,500.000 төгрөгийн зардлыг шийдүүлэн авч гадна гэрэлтүүлэг гэрлэн хаягыг хийж гүйцэтгэлээ.

Номын сангийн хувьд энэ сард сумын Шинээр ирсэн номнуудыг Халзан сум Соёлын төв гэсэн фээж хуудсаар дамжуулан уншигч үйлчлүүлэгч нартаа танилцуулан гэрээр ном олгох үйлчилгээг үзүүлж байна.

Намрын эхэн сарын шинийн 3 билэгт сайн өдөр Билэгт хувилгааны найм дахь дүрийн үр хүүхдүүд Хатавчийн хийдийн хашаанд Гэрэлт хөшөө босгож түүний үйл ажиллагаанд соёлын төвийн ажилчид ая дуугаа өргөж хамтарч ажиллалаа. Мөн аймгийн Гэр бүл хүүхэд залуучуудын хөгжлийн газраас зохион байгуулсан Дарьганга марзай уралдаанд соёлын төвийн ажилтан Б.Батбаатар 2 хүүхэд бэлтгэн оролцуулан идэвхи санаачлагатай ажиллаж О.Мишээл гутгаар байр О.Давааням тусгай байранд тус тус шалгарч амжилттай оролцлоо.

Эрүүл мэндийн чиглэлээр: 9 дүгээр нийт сард батлагдсан тохиолдол болох 78 иргэнийг эмнэлэгт эмчилж ажиллаж байна. Улаан бүсэд 1 их эмч, 1 сувилагч, 1 үйлчлэгч 14 хоноод 2 дахь ээлжийн 1 бага эмч, 2 үйлчлэгч 2 сувилагч ажиллаж байна. Тандалтын 2 баг ажиллаж, батлагдсан иргэдийн ар гэрийн ойрын хавьтал тогтоох, ариутгал халдваргүйтгэл хийх ажлуудыг хийж гүйцэтгэж байна. Нийт 240 иргэнээс түргэвчилсэн шинжилгээ авч ажилласан. Одоогийн байдлаар сумын эмнэлэгт 46 хүн хэвтэн эмчүүлж байгаагаас 1 хүний биеийн байдал хүндэвтэр, 1 хүн сэжиглэн эмчлэгдэж, 45 хүн хөнгөн байна. Үүнээс 9 хүүхэд байна, жирэмсэн байхгүй.

9 дүгээр сарын 24 ны байдлаар 2 -12 насны 190 хүүхэд томуугийн вакцинд хамрагдаад байна.

Жижиг дунд үйлдвэрлэл, хөдөө аж ахуйн чиглэлээр: 2021 оны 09-р сарын 22-ны байдлаар нийт 9 зээлдэгч байгаагаас 2021 оны 09 сарын зээлийн эргэн төлөлтийн орлого 3 хүнээс 944.000 мянган төгрөгний орлого Сум хөгжүүлэх сангийн дансанд төвлөрүүлсэн байна. Нийт зээлдүүлэгч нартай утсаар болон биеэр очиж уулзан хугацаандаа зээлээ эргэн төлөх талаар мэдээлэл, зөвлөгөө өгч ажиллалаа.

Сум хөгжүүлэх сангийн зээлдэгч Ц.Идэрбатыг дэмжих зорилгоор Хүүхдийн цэцэрлэг, ЕБС-н захирал нартай уулзаж сүү сүүн бүтээгдэхүүн нийлүүлэх гэрээ хийж ажилласан.

“Covid-19” цар тахалтай холбогдуулан сумын хүнсний гол нэрийн бүтээгдэхүүний нөөцийн судалгааг аймгийн ХХААГазарт сар бүр мэдээлж байна.

Газар тариалан эрхлэгчдийн тариалалт ургац хураалтын мэдээ нэгтгэлийг ХАА программ дээр шивэлт хийж ажиллав.

“Covid-19” цар тахалтай холбогдуулан улсын онцгой комиссын 41-р түр журмын дагуу хүнсний дэлгүүрүүдээр хяналт шалгалт хийж мэдээ нэгтгэлийг аймгийн МХГ-т хүргүүлэн ажиллалаа

Хөдөө аж ахуйн чиглэлээр: “Тэргүүн сүрэг” ХХК-тай 1212500 төгрөгний бод богын ээмэгний гэрээ байгууллан, захиалгын дагуу ээмгээ хүлээн авч, үржлийн малын ангилалт, баталгаажуулалт, цөм сүрэг бүрдүүлэх ажлыг зохион байгуулах сумын засаг даргын захирамжаар ажлын хэсгийг томилон ээмэгжүүлэлтийн ажил эхлэлээ.

2021-2022 оны Өвөлжилт, хаваржилтын бэлтгэл ажлыг хангах аймгийн засаг даргын 07 албан даалгаварын дагуу сумын засаг даргын албан даалгавар гарган төлөвлөгөө гарган ажиллаж байна.

Мал эмнэлэгийн чиглэлээр: Шүлхийн вакцины нэгтгэлийг мал эмнэлгийн нэгтсэн системд оруулж мал эмнэлгийн газартай тулгалт хийж дууссан. Орон нутгийн захиалгат Дуут, боом, дхх, лестериоз, сахуу, цусан халдвартын вакцин хийгдэж дуусаад нэгтгэх шатандаа явж байна. Мал эмнэлгийн ерөнхий газраас Болдбаатар байцаагч сум аймгийн тасгийн байцаагч нарыг чадвахжуулах зорилгоор сургалт мэдээллийг google meet ашиглан заавар зөвлөгөө өгч ажиллалаа.

Хээлтүүлэгч малын шинжилгээний ажил эхлээд 20 хувьтай явагдаж байна , нийт 4 мал эмнэлгийн 5 малын эмч ажиллаж байна.

Байгаль орчны чиглэлээр: Ой хээрийн түймэрийн эрсдэлийн үнэлгээг гаргаж аймгийн онцгой байдлын газарт хүргүүлэн ажиллав.

Шонхор шувуу барих отгийн үйл ажиллагаанд хяналт тавьж ойр орчмын хог хаягдлыг цэвэрлүүлэх ажлыг нийт 3 удаа зохион байгуулж ажиллалаа.

ХЯНАСАН: ТАМГЫН ГАЗРЫН ДАРГА:

М.БАТБЭХ

МЭДЭЭ НЭГТГЭСЭН: ХУУЛЬ ЭРХ ЗҮЙ
МЭРГЭЖИЛТЭН

ХАРИУЦСАН
Д.ДАЙРИЙМАА